

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/169/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2025 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	18-20
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18-19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19-20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	20-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23-24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЦЭРЭНТОГТОХ
ТАНАА

2025.02.24 № СА-2025/109/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ЭМЯ болон аймгийн хөрөнгө оруулалтаар 1,311,352.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, хөрөнгөд бүртгэсэн байна.

Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-аар тайлант оны 4 сараас эхлэн орон нутгийн нэмэгдэл авсан зэргээс шалтгаалж тус газрын 2024 оны цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 27.9 хувиар нэмэгдсэн бөгөөд урсгал зардлын 60.0 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал эзэлж байна.

4325027543

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг нь 2010 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаа эрүүл мэндийн байгууллагын онцлогт нийцэхгүй, тухайн цаг үеэс хойш нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зэрэг хууль эрх зүйн актуудад орсон өөрчлөлтүүд мөрдөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	846,322,547.68	1,237,428,895.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	187,536,438.53	14,771,206.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	187,536,438.53	14,771,206.49
3121	Төгрөг	187,536,438.53	14,771,206.49
31211	Төрийн сангийн харилцах	187,536,438.53	14,771,206.49
33	АВЛАГА	118,954,411.00	704,554,341.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	115,954,411.00	660,886,197.00
335	Бусад авлага	3,000,000.00	39,664,144.00
3351	Байгууллагаас авах авлага	3,000,000.00	3,310,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	539,831,698.15	518,103,347.94
351	Түүхий эд материал	506,916,954.15	485,049,513.94
35110	Тусгай зориулалттай материал	47,634,400.00	47,634,400.00
35130	Эм боох материал	459,282,554.15	437,415,113.94
354	Хангамжийн материал	32,914,744.00	33,053,834.00
35410	Бичиг хэргийн материал	6,372,740.00	8,528,530.00
35420	Аж ахуйн материал	7,527,108.00	6,503,450.00
35430	Сэлбэг хэрэгсэл	8,229,320.00	8,021,640.00
35440	Түлш, шатах тослох материал	4,680,000.00	2,532,769.00
35450	Барилгын засварын материал	1,660,600.00	1,111,100.00
35460	Хүнсний материал	4,444,976.00	6,356,345.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	19,065,849,670.38	17,232,555,842.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	19,065,849,670.38	17,232,555,842.94
392	Биет хөрөнгө	18,642,921,670.38	16,794,853,505.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,519,535,569.00	10,452,054,669.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-981,319,048.73	-1,399,155,185.19
39203	Авто-тээврийн хэрэгсэл	549,383,623.00	998,152,214.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	-98,217,783.38	-179,561,772.66
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,917,286,301.07	11,075,008,289.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,112,437,724.99	-4,724,064,071.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,176,753,125.73	1,068,362,513.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	-331,686,958.07	-499,453,258.81
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,578,400.00	4,578,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-953,833.25	-1,068,293.24
393	Биет бус хөрөнгө	422,928,000.00	437,702,337.50
39301	Програм хангамж	11,815,000.00	12,494,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,335,000.00	-11,942,462.50
39303	Бусад биет бус хөрөнгө	416,448,000.00	437,150,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	19,912,172,218.06	18,469,984,738.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,655,438,662.75	2,698,356,262.86
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,655,438,662.75	2,698,356,262.86
413	Өглөг	1,655,438,662.75	2,698,356,262.86
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	100,360,171.97	1,393,867,670.85
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,476,231,036.78	1,237,868,573.01
4136	Бусад өглөг	78,847,454.00	66,620,019.00
41361	Байгууллагад төлөх өглөг	78,847,454.00	55,020,019.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	18,256,733,555.31	15,771,628,475.51
51	Засгийн газрын хувь оролцоо	18,256,733,555.31	15,771,628,475.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,303,619,352.00	3,303,619,352.00
51101	Өмч: - төрийн	3,303,619,352.00	3,303,619,352.00
512	Хуримтлагдсан үр дүн	7,595,806,524.83	5,110,701,445.03
51210	Өмнөх үеийн үр дүн	7,595,806,524.83	7,595,806,524.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,357,307,678.48	7,357,307,678.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	19,912,172,218.06	18,469,984,738.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	14,258,162,894.02	15,515,166,828.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,217,610,367.02	1,859,384,143.10
120	Нийтлэг татварын бус орлого	3,511,300,481.82	548,032,104.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,511,300,481.82	548,032,104.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	338,257,857.00	343,850,480.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	424,959,324.00	54,563,690.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,748,083,300.82	149,617,934.09
122	Тусламжийн орлого	706,309,885.20	1,311,352,039.00
122001	Хандив тусламж /дотоод/	706,309,885.20	1,311,352,039.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,040,552,527.00	13,655,782,685.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	1,068,619,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	1,068,619,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,040,552,527.00	12,587,163,685.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,040,552,527.00	12,587,163,685.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,376,455,880.76	17,237,716,702.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,376,455,880.76	17,237,716,702.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,328,927,080.76	17,197,302,396.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,664,693,155.46	9,248,324,859.00
210101	Үндсэн цалин	3,665,713,580.49	5,448,963,475.46
210102	Нэмэгдэл	2,288,446,735.89	3,115,992,755.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	168,896,442.86	236,677,804.32
210104	Урамшуулал	541,636,396.22	446,690,824.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	841,909,998.43	1,096,617,858.51
210201	Тэтгэврийн даатгал	590,270,708.13	750,093,365.34
210202	Тэтгэмжийн даатгал	69,506,242.38	92,782,907.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	57,175,028.09	65,837,097.83
210204	Ажилгүйдлийн даатгал	11,249,084.01	37,388,442.49
210205	Эрүүл мэндийн даатгал	113,708,935.82	150,516,044.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	927,461,255.70	969,751,599.41
210301	Гэрэл, цахилгаан	161,427,723.30	166,504,676.40

210302	Түлш, халаалт	456,259,858.00	582,195,367.01
210303	Цэвэр, бохир ус	309,773,674.40	221,051,556.00
2104	Хангамж, бараа материалын зардал	239,897,916.16	267,731,157.16
210401	Бичиг хэрэг	26,410,950.00	22,661,360.00
210402	Тээвэр, шатахуун	92,897,136.14	97,127,802.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,180,050.02	23,572,332.16
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,385,985.00	10,928,895.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	91,023,795.00	113,440,768.00
2105	Нормативт зардал	2,561,531,104.73	2,830,077,345.46
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,275,360,855.23	2,513,367,340.46
210502	Хоол, хүнс	242,161,049.50	293,608,795.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	44,009,200.00	23,101,210.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	87,284,750.00	114,174,912.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	5,316,000.00
210604	Урсгал засвар	87,284,750.00	108,858,912.00
2107	Томилолт, зочны зардал	19,891,200.00	25,494,250.00
210701	Гадаад албан томилолт	114,000.00	218,400.00
210702	Дотоод албан томилолт	19,777,200.00	25,275,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,633,540.00	108,207,537.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,529,568.00	67,310,039.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,735,350.00	10,390,885.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	525,262.00	446,250.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,495,000.00	21,583,593.58
210807	Газрын төлбөр	400,000.00	362,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,783,360.00	8,114,770.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,917,624,160.28	2,536,922,877.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,163,078.50	8,690,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,900,461,081.78	2,528,232,277.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,528,800.00	40,414,306.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,528,800.00	30,950,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	47,528,800.00	30,650,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	9,463,506.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,463,506.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	881,707,013.26	-1,722,549,874.61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	331,148,198.69	762,555,205.19
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	662,230,369.44
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	331,148,198.69	100,324,835.75
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-331,148,198.69	-762,555,205.19
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>550,558,814.57</u>	<u>-2,485,105,079.80</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	10,676,737,297.00	13,511,265,069.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	752,139,181.00	400,414,170.01
120	Нийтлэг татварын бус орлого	752,139,181.00	400,414,170.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	752,139,181.00	400,414,170.01
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	327,179,857.00	343,850,480.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	424,959,324.00	56,563,690.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,924,598,116.00	13,110,850,899.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	1,068,619,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	1,068,619,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,924,598,116.00	12,042,231,899.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,924,598,116.00	12,042,231,899.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,469,994,816.65	13,639,253,521.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,469,994,816.65	13,639,253,521.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,426,880,416.65	13,616,821,214.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,642,842,719.71	8,239,464,223.83
210101	Үндсэн цалин	3,548,236,657.58	4,290,967,779.06
210102	Нэмэгдэл	2,384,073,222.75	3,293,435,243.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	168,896,443.16	218,319,261.36
210104	Урамшуулал	541,636,396.22	436,741,939.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	764,125,261.61	852,329,138.80
210201	Тэтгэврийн даатгал	560,162,950.74	557,572,096.84
210202	Тэтгэмжийн даатгал	56,166,992.71	76,964,293.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	46,736,828.31	45,224,322.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,101,130.00	36,814,704.10
210205	Эрүүл мэндийн даатгал	91,957,359.85	135,753,722.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	813,458,629.30	1,138,776,225.81
210301	Гэрэл, цахилгаан	161,427,723.30	166,504,676.40
210302	Түлш, халаалт	329,877,964.00	698,599,261.01
210303	Цэвэр, бохир ус	322,152,942.00	273,672,288.40
2104	Хангамж, бараа материалын зардал	186,155,321.89	253,192,976.43
210401	Бичиг хэрэг	11,132,550.00	18,495,120.00
210402	Тээвэр, шатахуун	96,483,536.14	82,399,302.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,019,542.75	26,688,059.43
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,075,985.00	19,497,895.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,443,708.00	106,112,600.00
2105	Нормативт зардал	1,841,365,576.14	2,829,857,155.01
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,600,665,240.64	2,463,917,188.01
210502	Хоол, хүнс	205,984,735.50	343,008,857.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	34,715,600.00	22,931,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,974,305.00	154,000,462.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,655,005.00	36,924,500.00
210602	Тавилга	00.00	555,390.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,349,000.00	2,841,520.00
210604	Урсгал засвар	56,970,300.00	113,679,052.00
2107	Томилолт, зочны зардал	19,125,800.00	22,158,800.00
210702	Дотоод албан томилолт	19,125,800.00	22,158,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,171,048.00	105,012,382.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,540,386.00	53,420,839.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,735,350.00	9,411,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	525,262.00	436,250.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,033,000.00	22,661,593.58
210807	Газрын төлбөр	400,000.00	362,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	12,772,050.00	18,720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,661,755.00	22,029,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,661,755.00	22,029,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,114,400.00	22,432,306.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,114,400.00	12,968,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,114,400.00	12,968,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	9,463,506.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,463,506.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	206,742,480.35	-127,988,452.04
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	29,590,000.00	44,776,780.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,590,000.00	44,776,780.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,590,000.00	44,776,780.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,590,000.00	44,776,780.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-29,590,000.00	-44,776,780.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	177,152,480.35	-172,765,232.04
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,383,958.18	187,536,438.53
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	187,536,438.53	14,771,206.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	3,303,619,352.00	7,422,036,914.47	-814,488,479.45	9,911,167,787.02
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,303,619,352.00	7,422,036,914.47	-814,488,479.45	9,911,167,787.02

C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,031,666,743.74	1,031,666,743.74
C08	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,303,619,352.00	7,357,307,678.48	7,595,806,524.83	18,256,733,555.31
D01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,303,619,352.00	7,357,307,678.48	7,595,806,524.83	18,256,733,555.31
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,303,619,352.00	7,357,307,678.48	7,595,806,524.83	18,256,733,555.31
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,485,105,079.80	-2,485,105,079.80
D09	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,303,619,352.00	7,357,307,678.48	5,110,701,445.03	15,771,628,475.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,276,000,200.00	13,674,566,794.46	601,433,405.54	95.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,276,000,200.00	13,674,566,794.46	601,433,405.54	95.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,257,000,200.00	13,661,597,994.46	595,402,205.54	95.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,405,444,200.00	8,239,464,223.83	165,979,976.17	98.03
210101	Үндсэн цалин	4,212,356,200.00	4,290,967,779.06	(78,611,579.06)	101.87
210102	Нэмэгдэл	3,474,327,500.00	3,293,435,243.74	180,892,256.26	94.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	353,133,100.00	218,319,261.36	134,813,838.64	61.82
210104	Урамшуулал	365,627,400.00	436,741,939.67	(71,114,539.67)	119.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	967,555,500.00	852,329,138.80	115,226,361.20	88.09
210201	Тэтгэврийн даатгал	654,440,800.00	557,572,096.84	96,868,703.16	85.20
210202	Тэтгэмжийн даатгал	78,278,700.00	76,964,293.34	1,314,406.66	98.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	39,139,300.00	45,224,322.00	(6,085,022.00)	115.55
210204	Ажилгүйдлийн даатгал	39,139,300.00	36,814,704.10	2,324,595.90	94.06
210205	Эрүүл мэндийн даатгал	156,557,400.00	135,753,722.52	20,803,677.48	86.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,169,338,100.00	1,138,776,225.81	30,561,874.19	97.39
210301	Гэрэл, цахилгаан	192,230,800.00	166,504,676.40	25,726,123.60	86.62
210302	Түлш, халаалт	681,539,500.00	698,599,261.01	(17,059,761.01)	102.50
210303	Цэвэр, бохир ус	295,567,800.00	273,672,288.40	21,895,511.60	92.59
2104	Хангамж, бараа материалын зардал	274,379,400.00	253,192,976.43	21,186,423.57	92.28
210401	Бичиг хэрэг	6,642,000.00	18,495,120.00	(11,853,120.00)	278.46
210402	Тээвэр, шатахуун	88,917,300.00	82,399,302.00	6,517,998.00	92.67
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,597,700.00	26,688,059.43	(13,090,359.43)	196.27
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	22,777,800.00	19,497,895.00	3,279,905.00	85.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	142,444,600.00	106,112,600.00	36,332,000.00	74.49

2105	Нормативт зардал	3,000,899,100.00	2,831,107,155.01	169,791,944.99	94.34
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,835,137,200.00	2,465,167,188.01	369,970,011.99	86.95
210502	Хоол, хүнс	135,762,100.00	343,008,857.00	(207,246,757.00)	252.65
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,999,800.00	22,931,110.00	7,068,690.00	76.44
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	241,166,600.00	196,847,442.00	44,319,158.00	81.62
210601	Багаж, техник, хэрэгсэл	52,100,000.00	75,189,480.00	(23,089,480.00)	144.32
210602	Тавилга	4,399,800.00	5,137,390.00	(737,590.00)	116.76
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.00	2,841,520.00	1,158,480.00	71.04
210604	Урсгал засвар	180,666,800.00	113,679,052.00	66,987,748.00	62.92
2107	Томилолт, зочны зардал	22,166,700.00	22,158,800.00	7,900.00	99.96
210702	Дотоод албан томилолт	22,166,700.00	22,158,800.00	7,900.00	99.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	153,424,900.00	105,692,182.58	47,732,717.42	68.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	79,511,200.00	53,420,839.00	26,090,361.00	67.19
210803	Даатгалын үйлчилгээ	9,411,700.00	9,411,700.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	509,200.00	436,250.00	72,950.00	85.67
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,748,600.00	23,341,393.58	19,407,206.42	54.60
210807	Газрын төлбөр	362,000.00	362,000.00	-	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	170,000.00	00.00		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,712,200.00	18,720,000.00	1,992,200.00	90.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,625,700.00	22,029,850.00	595,850.00	97.37
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,625,700.00	22,029,850.00	595,850.00	97.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,000,000.00	12,968,800.00	6,031,200.00	68.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,000,000.00	12,968,800.00	6,031,200.00	68.26
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,000,000.00	12,968,800.00	6,031,200.00	68.26
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,415,356,938.53	13,501,801,562.42	(86,444,623.89)	100.64
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,089,338,100.00	1,059,155,493.41	30,182,606.59	97.23
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,794,394,100.00	12,042,231,899.00	(247,837,799.00)	102.10
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,794,394,100.00	12,042,231,899.00	(247,837,799.00)	102.10
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	531,624,738.53	400,414,170.01	131,210,568.52	75.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	323,646,400.00	343,850,480.01	(20,204,080.01)	106.24
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,441,900.00	56,563,690.00	(36,121,790.00)	276.70
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	187,536,438.53			
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	187,536,438.53		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	14,771,206.49		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг /цаашид аймгийн Нэгдсэн эмнэлэг гэх/ нь "Иргэдийн сонголт, эмчилгээний нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг мэдлэгтэй, чадвартай, сэтгэлтэй, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ээлтэй, эрсдэлгүй, аюулгүй орчинд үзүүлэхэд оршино" гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон, хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

- Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үед эх, ураг, нярайд эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх эх барихын тусламж, үйлчилгээ,
- Хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж,
- Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ,
- Өвчин эмгэг бүхий үйлчлүүлэгчийг асран сувилах замаар эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ,
- Өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дугаар сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлт тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Эрүүл мэндийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 17, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,

- ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 29-ний “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 06 дугаар тогтоол, 10 дугаар сарын 03-ны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 14 дүгээр тогтоол гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2010 онд боловсруулагдсан Эрүүл мэндийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан *Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,442,187.4 мянган төгрөгөөр буюу 7.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	187,536.40	14,771.20	(172,765.20)
Авлага	118,954.40	704,554.30	585,599.90
Бараа материал	539,831.70	518,103.40	(21,728.30)
Үндсэн хөрөнгө	19,065,849.70	17,232,555.80	(1,833,293.90)
Нийт хөрөнгө	19,912,172.20	18,469,984.70	(1,442,187.50)
Өр төлбөр	1,655,438.60	2,698,356.30	1,042,917.70
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	18,256,733.60	15,771,628.50	(2,485,105.10)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	19,912,172.20	18,469,984.80	(1,442,187.40)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 172,765.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд ЭМЯ-аас өр төлбөр барагдуулахад зориулж олгосон нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулснаас,
- Авлага данс 704,554.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь ЭМДС-аас авах санхүүжилтийн 660,886.2 мянган төгрөгийн авлага тайлагнагдсанаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,232,555.8 мянган төгрөг болж 1,833,293.9 мянган төгрөгөөр буурсан нь ЭМЯ, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1,311,352.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХ-ын 2024 оны 158 дугаар тогтоолоор 905,167.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант онд 2,528,232.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан зэргээс голлон шалтгаалсан,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 2,698,356.3 мянган төгрөг болж 1,042,917.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үзүүлсэн эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийг ЭМДС-аас дутуу төвлөрүүлснээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-ийн санхүүжилтээс 11,342,082.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 590,271.0 мянган төгрөг зэрэг нийт 11,932,253.0 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,430,704.1 мянган төгрөгөөр бууруулж, 10,501,648.9 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Тогтмол зардлыг 962,800.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 693,149.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 65,000.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 40,000.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 32,046.6 мянган төгрөгөөр бууруулж,
- ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 335,695.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 45,180.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 3,774,351.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн тодотгол, зохицуулалт хийж, **14,276,000.2** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 1,789,443.7 мянган төгрөгөөр
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 989,338.1 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 733,758.4 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 101,166.6 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 95,806.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 11,794,394.1 мянган төгрөгийг ЭМДС-ийн санхүүжилтээс, 1,089,338.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 323,646.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 20,441.9 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдэл санхүүжилтээс 187,536.4 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр ЭМДС-аас 12,042,231.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,059,155.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 343,850.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 56,563.7 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 13,674,566.7 мянган төгрөг буюу 95.8 хувьтай тайлагнагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	12,142,757.1	11,847,186.7	295,570.4	97.6
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	19,000.0	12,968.8	6,031.2	68.3
3	Төр төлбөрийг нь хариуцах эмийн зардал	74,945.7	74,945.7	-	100.0
4	Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан	949,959.3	680,310.0	269,649.3	71.6
5	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	1,089,338.1	1,059,155.5	30,182.6	97.2

	Дүн	14,276,000.2	13,674,566.7	601,433.5	95.8
--	-----	--------------	--------------	-----------	------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

/мянган төгрөг/				
№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам /Тендер шалгаруулалтын арга
1	Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах	2,079,087.4	2,035,083.4	НТШ
2	Түргэн тусламжийн автомашины шатахуун, тослох материал нийлүүлэх	101,803.7	101,803.7	НТШ
3	Хоол хүнсний материал нийлүүлэх	148,053.3		НТШ
	Нийт дүн	2,328,944.4	2,136,887.1	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зохион байгуулан, шалгарсан дараах аж ахуйн нэгжүүдтэй бараа материал нийлүүлэх гэрээг байгуулан ажилласан байна.

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн 49 багцаас 48 багцад Ази фарм, Агниста фарм, Айвико хэлт кэйр, Их шүүдэргэнэ, Медиконт, Медклийн, Монбиофарм, Монгол эм импекс, Монос трейд, Монфа трейд, Мөнхийн тун, Сетунари, Сүвэн уул, Тэгш анар, Лайфтроник, Антегин, Энто ХХК зэрэг компаниуд, шатахуун, шатах тослох материал нийлүүлэх тендерт Сод Монгол ХХК шалгарч, гэрээ байгуулан, худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн 1 багц, хоол хүнсний материал нийлүүлэх, тендерүүд нь амжилтгүй болсон тул өмнөх онуудад гэрээний үндсэн дээр бэлтгэн нийлүүлэлт хийж байсан Сэлэнгэ баян уул, Алтан тариа, Галил-Этоос, Цахим

ертөнц зэрэг байгууллагуудтай гэрээ байгуулан, худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна.

4.АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн шүүхийн шийдвэрээр олгосон цалинг ХХОАТ-ын тайланд нөхөн тайлагнах, нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлэх, илүү цагийн хөлсийг нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсаар тооцож, олгохтой холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 14,258,162.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 142,581.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шатахууны зардлыг хэмнэх зорилгоор автомашинуудад байршил тогтоогч суурилуулсан,
- Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүд, бусад арга хэмжээнүүдтэй холбогдуулан контент, аялал зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулаагүй зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд тус эмнэлгийн мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллээс 26 төрлийн 166 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, "Дараа жилийн төсвийн төсөл, "Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан" зэрэг 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн

гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 185,660.4 мянган төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
АКТ					
Албан шаардлага	3	185,660.4	3	185,660.4	100.0
Зөвлөмж	1		1		100.0
Нийт дүн	4	185,660.4	4	43,632.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудит болон дараагийн аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Тайлант онд ЭМДЕГ-тай байгуулсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний 2.4.2-т “Төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглабартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар саруудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хуанлийн 2 хоногт багтаан илгээх, 11-ний өдрөөс тухайн сар дуусталх хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэлтэй хамтатган хүргүүлэх” гэж заасныг мөрдлөг болгон ЭМДС-аас авах 12 дугаар сарын 11-ээс 31-ийг хүртэлх хугацаанд үзүүлсэн тусламж үйлчилгээний авлага болох 880,274.9 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2: “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2. Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/323, 2021 оны А/214 дугаар захирамжуудаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулсан боловч уг захирамжууд нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9.2, 17.9.3, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3, 15.10 дахь заалтуудыг зөрчсөн тул зөвлөл үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоо бүрдээгүй байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийг байгуулаагүй байгаа нь эмнэлгийн тухай жилийн төсвийг хэлэлцэж батлах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар,

хүртээмжийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, эмнэлгийн тухай жилийн төсвийн зарцуулалтад хяналт тавих ажлууд хийгдэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 97,669.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогыг 33,053.0 мянган төгрөгөөр, бараа материалын орлогыг 13,981.0 мянган төгрөгөөр, цалингийн зардлыг 36,354.1 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан,
2. Тайлант жилд шинээр нэмэгдсэн зарим үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 14,281.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Аудитаар нийт **98,105.8** мянган төгрөгийн зөрчил² илэрч, 62,494.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн 35,610.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага

1. Сэлэнгэ аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 148/ШШ2024/00162 дугаар шийдвэр болон 10 дугаар сарын 08-ны өдрийн 148/ШШ2024/00489 дугаар шийдвэрээр Дэмжих үйлчилгээний албаны дарга албан тушаалтай Б.Эрдэнэчимэгийн ажилгүй байсан хугацааны 35,610.9 мянган төгрөгийн цалин хөлсийг байгууллагаас барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагад учруулсан хохирлыг буруутай албан хаагчаар нөхөн төлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Анхан шатны баримтын бүрдэл дутуу **23,484.0** мянган төгрөгийн дараах ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- Үзүүлсэн хууль, эрх зүйн туслалцаа, хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, нэгж үйлчилгээний үнэ тариф тодорхой бус зэрэг анхан шатны нотлох баримтгүйгээр зөвхөн "Хамтран ажиллах гэрээ", нэхэмжлэхийг үндэслэн хуулийн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"Өмгөөллийн Эф Би Эл Си" ХХК-д 12,500.0 мянган төгрөг шилжүүлж, 9,750.0 мянган төгрөгийн өглөг үүсгэн нийт 22,000.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

- Томилолтоор ажилласан байгууллагын холбогдох албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулаагүй албан томилолтын хуудсаар тус эмнэлгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэнтогтох-д 1,234.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг тооцож олгосон.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ авахаар байгуулсан гэрээг таслан зогсоох, хүчин төгөлдөр, баталгаажсан анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Эмийн зардлаас багаж техник хэрэгслийн зардалд 2,500.0 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаас хог хаягдал, зайлуулах зардалд 900.0 мянган төгрөгийг зэрэг нийт 3,400.0 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. ХХОАТ-ын тайлантай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: ХХОАТ-ын тайланд шүүхийн шийдвэрээр олгосон 35,610.9 мянган төгрөгийн цалинг нөхөн тайлагнаагүй байгаа нь татварын авлага, өглөг үүсэх эрсдэлийг үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Шүүхийн шийдвэрээр олгосон цалинг ХХОАТ-ын тайланд нөхөн тайлагнах.

2. Санхүүжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-ын шалгуурыг хангаагүй тул ЭМДС-аас нэхэмжилсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь эх олонлогийн, системийн, эмч, байцаагчийн гэсэн 4 төрлөөр 1,068,091.3 мянган төгрөгөөр хасагдсан байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Сар бүр нэхэмжлэхийн хяналтаар хасагдсан тусламж, үйлчилгээний санхүүжилтэд дүн шинжилгээ хийж, дотоод хяналтыг хэрэгжүүлэх замаар тусламж, үйлчилгээний орлогын бүрэн төвлөрүүлэх.

3. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудасгүйгээр буюу илүү цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулалгүйгээр нягтлан бодогч, нярав, хүний нөөцийн ажилтан зэрэг албан хаагчдад илүү цагийн хөлсийг тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1-д “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулсны дараа олгож байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогыг дутуу тайлагнасан.	1	33,053.0			1	33,053.0	1	33,053.0				
Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг дутуу тайлагнасан.	1	13,981.0			1	13,981.0	1	13,981.0				
Цалингийн зардлыг дутуу тайлагнасан.	1	36,354.1			1	36,354.1	1	36,354.1				
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан.	1	14,281.4			1	14,281.4	1	14,281.4				
Дүн	4	97,669.5			4	97,669.5	4	97,669.5				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагад учруулсан хохирлыг буруутай албан хаагчаар нөхөн төлүүлэх	1	35,610.9			1	35,610.9						
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйцэтгэгч, бүртгэлд тусгасан.	1	23,484.0			1	23,484.0						

/мянган төгрөгөөр/

Төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	3,400.0		1	3,400.0				
Цалинг ХХОАТ-ын тайланд нөхөн тайлагнаагүй.	1	35,610.9				1	35,610.9		
Нэхэмжлэлийн хяналтаар санхүүжилт хасагдсан.	1	-				1	-		
Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудасгүйгээр илүү цагийн нэмэгдлийг олгосон.	1	-				1	-		
Дүн	6	98,105.8		3	62,494.9	3	35,610.9		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/МЯНГАН ТӨГРӨГӨӨР/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс							
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	1	-						1	
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	1							1	